



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар A/07

Залаа

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр  
2025 онд санхүүжүүлэх ажлын санал авах,  
эрэмбэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.5, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийх ажлын санал авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батхуяг

(Тамгын газрын дарга)

Гишүүд:

Х.Дагважав

(Санхүүгийн албаны дарга)

Б.Ганбат

(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ш.Бямбацогоо

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

С.Хишигтогтох

(Нягтлан бодогч)

Д.Энхдалай

(Зараа 1 дүгээр багийн Засаг дарга)

М.Болдцэрэн

(Уртын гол 2 дугаар багийн Засаг дарга)

Б.Ангирмаа

(Эрдэнэшанд 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Энхтулга

(Эхэнхавцгай 4 дүгээр багийн Засаг дарга)

642301173

F:\2024\ZD\Zahiramj.docx

Д.Энх-Амгалан

(Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: У.Мөнхнаран

(Газрын даамал)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болох хөрөнгийн жагсаалтыг багуудаас ирсэн санал нь олонхоор дэмжигдсэн, сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд нийцсэн байх, гэх мэт журманд заасан үзүүлэлтүүдээр хугацаанд нь эрэмбэлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу саналын хуудсанд тусгагдаагүй, иргэдээс санал аваагүй, дэмжигдээгүй ажлыг 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төсөлд оруулж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхгүй байхыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбадорж)-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ